



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/165

Бат-Өлзий сум

Орон тооны бус зөвлөлийг шинэчлэн  
байгуулах тухай

Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/77 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид тэтгэвэр тогтоолгох баримтлах журмын дагуу малчнаар ажиллаж байсан хугацааг тодорхойлох сумын үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

П.Аюушжав (Мал эмнэлгийн улсын байцаагч)

М.Янжинлхам (“Санги хайрхан” мал эмнэлгийн малын эмч)

Д.Нансалмаа (Нийгмийн даатгалын байцаагч)

Э.Дашдулам (Статистик хариуцсан ажилтан)

Г.Дондогсэрчин (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Б.Ууганцэцэг (Нийгмийн Даатгалын улсын байцаагч)

2. Малчин даатгуулагчийг өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 1995 оноос хойш мал маллаж байсан эсэхийг зөв тодорхойлж, ашиг сонирхлоос ангид байж, үндэслэлтэй, үнэнч шударгаар хандан малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг зөв тогтоохыг орон тооны бус зөвлөлийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн тогтоол, тэмдэглэл, бүртгэлийг цаас болон цахим хэлбэрээр баримтжуулж, даатгуулагчийн нийгмийн даатгалын шилтгэл төлж малчнаар ажилласан хугацааг тодорхойлсон талаар тайлан мэдээг гаргаж улирал тутамд Нийгмийн даатгалын газарт тайлагнаж ажиллахыг (Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын “Орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” 2021 оны А/165 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

20210202